



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 130

Амардалай

Газар ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам", сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 04 тоот тогтоолоор баталсан "Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Ю Пи Си Дэлгэрцогт Лэнд Холдингс" ХХКомпани (741352011 м.кв)-д салхин сэнсний судалгааны талбайн зориулалтаар сумын Дэлгэр-Эмт багийн нутаг дэвсгэрт 74135 га газрыг 5 жилийн хугацаатай ашиглуулсугай.

Хоёр. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Д.Цэнд-Аюуш), хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Энхдэлгэр) нарт даалгасугай.

Гурав. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу ашиглаж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар ашиглагч "Ю Пи Си Дэлгэрцогт Лэнд Холдингс" ХХК-д үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

4880010071